

ОХУ-ын уур амьсгалын аюулгүй байдлын стратеги

Хүрэлийн Номинболор

Докторант, ахлах шинжээч, nominbolor@iss.gov.mn
Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
Стратеги судалгааны хүрээлэн

Хураангуй

Арктик болон мөнх цэвдэгт бүс нутагт дулаарал дэлхийн дунджаас дөрөв дахин хурдан явагдаж байна. Ялангуяа дэлхийд хамгийн том газар нутагтай Оросын холбооны улс (Орос) уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртсөнөөр энэ нь дэд бүтэц, биологийн олон янз байдал, эрчим хүч, хөдөө аж ахуй зэрэг гол салбарт эрсдэл дагуулж байна. Москва 2060 он гэхэд нүүрстөрөгчийн хувьд саармаг болох амлалт өгч, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогын баримт бичгүүдийг боловсруулсан ч шинжээчид эдгээр арга хэмжээг бодит өөрчлөлт авчрахгүй, дүр эсгэсэн шинжтэй хэмээн шүүмжилдэг. Учир нь малтмал түвшнээс хэт хамааралтай байдал, геополитикийн тэргүүлэх зорилтууд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах амлалтаас нь илүү чухалд тооцогдсон хэвээр байгаа. Иймд уур амьсгалын өөрчлөлт Оросын дотоодод дасан зохицох сорилт дагуулахын зэрэгцээ олон улсын харилцаанд ашиглагдах стратегийн хэрэгсэл болоод байна.

Энэхүү өгүүлэлд уур амьсгалын асуудлаарх Оросын байр суурь, хандлага, уур амьсгалын стратегийн талаар анализ хийв. Оросын уур амьсгалын аюулгүй байдлын стратегийн хоёр талт шинж (дотоодын эмзэг байдал хийгээд геополитикийн хөшүүрэг) нь уур амьсгалын өөрчлөлт дэлхийн аюулгүй байдал болон их гүрнүүдийн стратегийн зан төлөвийг хэрхэн өөрчилж байгаагийн илрэл хэмээн дүгнэж байна.

Түлхүүр үг: Уур амьсгалын өөрчлөлт, эмзэг байдал, Арктик, геополитикийн хөшүүрэг, Өрнөдийн бус эвсэл

Оршил

Уур амьсгалын өөрчлөлт энэ зууны хамгийн том сорилтуудын нэг болж, дэлхийн экологийн системийг төдийгүй улс орнуудын үндэсний аюулгүй байдал, геополитикийн суурийг өөрчилж байна. Дэлхийн хамгийн том газар нутаг, нүүрстөрөгчийн гаралтай баялагт тулгуурласан эдийн засаг, Арктикийн бүсийг хамарсан газарзүйн байрлал бүхий Оросын хувьд уур амьсгалын өөрчлөлт нэг талаас аюул занал, сорилт нөгөө талаас хөгжлийн шинэ боломж бий болгож байгаа юм.

Судалгаагаар Оросын зарим хэсэгт дулаарал дэлхийн дунджаас дөрөв дахин хурдан явагдаж байгаа нь дэд бүтцийн эвдрэл, биологийн олон янз байдлын алдагдал, ой хээрийн түймэр, үерийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Эдгээр дотоод эмзэг байдал нь Оросын эдийн засгийн тогтвортой байдал, эрчим хүчний экспорт, хүнсний аюулгүй байдалд шууд нөлөөлж буй.

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, зайлшгүй өөрчлөлтөд дасан зохицох хүрээнд Москва 2060 он гэхэд нүүрстөрөгчийн хувьд саармаг болох амлалт өгч, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, тогтвортой хөгжлийг дэмжих бодлогын баримт бичгүүдээ 2023 онд баталсан. Энэ бол тус улсын уур амьсгалын албан ёсны бодлого (climate policy)¹, олон улсын өмнө хүлээсэн амлалт гэж үзэж болно. Харин Оросын уур амьсгалын аюулгүй байдлын стратеги (climate security strategy) нь уур амьсгалын өөрчлөлтийг тус улсын аюулгүй байдалд учирч буй сорилт хэмээн үзэж, үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх, эрчим хүчний хөшүүрэг, геополитикийн байр суурьтай хамтад нь авч үздэг. Үүнийг аюулгүй байдлын зохих баримт бичгүүддээ ч тусгасан байдаг.

ОХУ-ын эдийн засаг малтмал түлшний нөөцөөс хэт хамааралтай, геополитикийн асуудлуудад тэргүүлэх ач холбогдол өгч байгаа өнөөгийн нөхцөлд уур амьсгалын талаарх байр суурь, стратеги нь дотооддоо төдийгүй дэлхийн хэмжээнд дараах үр дагавартай. Үүнд:

- Газрын тос, байгалийн хий, нүүрсний томоохон экспортлогчийн хувьд Оросын сонголт нь дэлхийн эрчим хүчний шилжилтэд үлэмж хэмжээгээр нөлөөлнө.
- Арктикийн мөс хайлснаар шинэ тээврийн зам, нөөцийн төлөөх геополитикийн өрсөлдөөн ширүүсэх бөгөөд Арктикийн бүсийн томоохон гүрний хувьд Орос үүнд ихээхэн үүрэгтэй.
- Уур амьсгалын дипломат ажиллагаан дахь Оросын оролцоо, эсхүл саад учруулалт олон улсын хамтын ажиллагааны үр ашигтай байдалд нөлөөлнө.
- Орост тохиож буй байгаль орчны гамшиг, цочролууд Евроазийн тээврийн коридор болон дэлхийн худалдааны урсгалыг тасалдуулж, нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдалд нөлөөлнө.

Иймээс Оросын уур амьсгалын аюулгүй байдлын стратегийг судлах нь байгаль орчны эрсдэл ба геополитикийн ашиг сонирхол хэрхэн огтлолцож буйг ойлгоход чухал ач холбогдолтой юм.

Нэг. ОХУ-ын уур амьсгалын бодлого

Орос хүлэмжийн хийн ялгаруулалтаар дэлхийд Хятад, Америк, Энэтхэгийн дараа дөрөвдүгээрт ордог. Сүүлийн 44 жилийн хугацаанд агаарын температурын дундаж өсөлт дэлхийн дунджаас 2.8 дахин их байсан тус улсад уур амьсгалын өөрчлөлтийн

¹ Уур амьсгалын бодлого (climate policy) нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах улс орны амлалт, зорилтууд, дасан зохицох стратегийн цогц юм.

улмаас тохиолдох гамшгийн давтамж, эрч байнга нэмэгдэж байна.² ОХУ-ын нийт газар нутгийн гуравны хоёр орчим нь зуны цагт ч үл гэсэх мөнх цэвдгээр хучигдсан байдаг бөгөөд дэлхийн дулаарлын улмаас энэхүү мөнх цэвдэг ихээхэн хэмжээний хүлэмжийн хийг ялгаруулах боломжтой. ОХУ-ын Аудитын танхимаас 2030 он гэхэд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас учирсан хохирлын өртөг Оросын ДНБ-ий 2-3 хувьд хүрч болзошгүйг тооцоолжээ.³

Хүснэгт 1. ОХУ-ын газар нутаг дахь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө⁴

Нөлөө	Тайлбар	Эерэг нөлөө	Сөрөг үр дагавар
Дундаж температур огцом нэмэгдэх	2020 оны байдлаар Оросын газар нутагт агаарын жилийн дундаж температур 1961-1990 оны олон жилийн дунджаас 3.2°C өндөр байв.	Уур амьсгалын бүсүүд хойд зүг рүү шилжиж, амьдрах чадвар нэмэгдэж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх шинэ газрууд нээгдэж байна.	Ой хээрийн түймэр; цөлжилт; шавьжаар дамжих өвчин нэмэгдэх; усны нөөцийн дарамт; зүйлийн эмзэг байдал; хэт халалтаас үүдэлтэй ажлын өдрийн алдагдал; эрүүл мэндийн яаралтай тусламж нэмэгдсэн.
Хур тунадас	Хур тунадас жилийн турш болон бүх улиралд ихэссэн, дэлхийн дунджаас өндөр.	ажиглагдаагүй	Үерийн эрсдэл нэмэгдсэн; гол мөрөн дээрх мөсний тогтворгүй байдал нэмэгдсэн; газрын тос, байгалийн хийн дэд бүтцийн материал, металл зэврэх процесс эрчимтэй явагдаж байна.
Хөрсний температур нэмэгдэж, мөнх цэвдэг гэсэх	Мөнх цэвдгийн бүсэд 0.8м гүн дэх хөрсний температур 10 жил тутамд 0.4-0.8 хэмээр нэмэгдэж байна.	Хөрсний бүтээмж нэмэгдэх	Дэд бүтцийн доголдол (жишээлбэл: барилга, төмөр зам, авто зам, газрын тосны цооног дахь хагарал); мөнх цэвдэгт хадгалагдсан метаны ялгарал; шинэ халдварт өвчний эрсдэл; барилгын өртөг нэмэгдэж байна.

² Koralova L. (2024.04.24). Russia’s epic floods expose lack of preparedness for climate crisis. *The Moscow Times*. <https://www.themoscowtimes.com/2024/04/24/russias-epic-floods-expose-lack-of-preparedness-for-climate-crisis-a84943> (2024.11.20-нд үзсэн).

³ Cordell, J. (2021.09.07). Climate change threatens Russia’s economic growth, watchdog warns. *The Moscow Times*. <https://www.themoscowtimes.com/2020/01/14/climate-change-threatens-russias-economic-growth-watchdog-warns-a68878> (2022.11.20-нд үзсэн).

⁴ Javeline, D., Orttung, R., Robertson, G., Arnold, R., Barnes, A., Henry, L., Holland, E., Omelicheva, M., Rutland, P., Schatz, E., Schenk, C., Semenov, A., Sperling, V., McIntosh Sundstrom, L., Troitskiy, M., Twigg, J., & Wengle, S. (2024). Russia in a changing climate. *WIREs Climate Change*, 15(2), e872. <https://doi.org/10.1002/wcc.872>

Хэт халалт	Хэт халах үзэгдэл ОХУ-ын Европ бүсэд түлхүү тохиолдож байна.	Мөсөн давхарга багасах	Ган, хар салхи, халууны давалгаа, хүйтэн бороо зэргийн давтаж нэмэгдэж байна.
Далайн түвшний өсөлт	Арктик орчмын далайн түвшний хэлбэлзэл урт хугацааны дунджаас өндөр байна.	-	Эргийн үер, элэгдэл ялангуяа Арктикт нэмэгдэж байна.
Арктикийн мөсний хэмжээ багасах	2004-2018 оны хүйтэн улирлын эцэст хойд туйлын мөсний дундаж зузаан 1997-2003 онтой харьцуулахад 40 см -ээр буурсан.	Хойд тэнгисийн зам нээгдэх, Арктикийн байгалийн нөөцийг ашиглах боломж нээгдэж байна.	Арктикийн амьтдын төрөл зүйлийн амьдрах орчин алдагдах, өөрчлөгдөх, уугуул иргэдийн амьжиргаа алдагдах эрсдэлтэй.

Уур амьсгалын номлол

ОХУ уур амьсгалын асуудлаарх суурь баримт бичиг болох “Уур амьсгалын номлол”-оо 2009 онд баталсан бөгөөд үүнд “Орчин үеийн шинжлэх ухаан хүний эдийн засгийн үйл ажиллагаа, ялангуяа малтмал түлшний шаталтаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарал уур амьсгалд чухал нөлөө үзүүлж байгааг улам хүчтэй нотолж байна” хэмээн хүлээн зөвшөөрсөн байдаг.⁵ Харин 2023 онд шинэчлэн баталсан хувилбар нь уур амьсгалын мониторинг, дасан зохицох арга хэмжээ, эрчим хүчний үр ашиг, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн хөгжил, “ногоон дипломат ажиллагаа” зэрэг асуудалд төвлөрч, 2060 он гэхэд нүүрстөрөгчийн хувьд саармаг болох зорилт дэвшүүлсэн.⁶ Гэхдээ малтмал түлшний шаталт болон хүлэмжийн хийн ялгарлын хоорондын шууд холбоог орхигдуулж, эрчим хүчний түлшний үр ашгийг дээшлүүлэх, ялгарлыг бууруулах санхүүгийн механизм, шинжлэх ухааны судалгаа, технологийг хөгжүүлэх хүрээнд малтмал түлшийг зөвхөн дурдсан байна. Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлт, хүлэмжийн хийн ялгарлын асуудлыг хүлээн зөвшөөрсөн ч “технологийн саармаг байдал” нэр томъёон дор газрын тос, байгалийн хий, цөмийн болон сэргээгдэх эрчим хүчийг дэмжин, ялгарлыг бууруулах болон шингээх арга хэмжээг аль алиныг онцолсон.

⁵ Climate Doctrine of the Russian Federation (2009). <https://www.climate-laws.org/geographies/russia/policies/climate-doctrine-of-the-russian-federation> (2022.11.22-нд үзсэн).

⁶ Russia approves New Climate Doctrine. Accessed December 15, 2025. <https://forumvostok.ru/en/news/v-rossii-utverzhdena-novaja-klimaticheskaja-doktrina/>.

Ялгарлыг бууруулах хүрээнд ойн экосистемд суурилсан байгалийн шингээлтийг нэмэгдүүлэх^{7,8}, цөмийн эрчим хүчний технологи, түлш баяжуулсан ураны гол ханган нийлүүлэгчийн байр сууриа давуу тал болгон ашиглах бодлого барьж байгаа. Төрийн өмчит корпораци Росатом цөмийн эрчим хүчний төслүүдээ дэлхий даяар, ялангуяа Даяар Өмнөд (Global South)-д өргөжүүлж, нөлөөгөө тэлэх үйл явц амжилттай өрнөж байна.

“Уур амьсгалын номлол” нь уур амьсгалын өөрчлөлт ХХI зууны хамгийн ноцтой сорилтуудын нэг бөгөөд ОХУ-ын хувьд салбар хоорондын цогц асуудал гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Уур амьсгал, аюулгүй байдлын уялдаа холбоонд уур амьсгалын өөрчлөлтийг “ОХУ-ын урт хугацааны аюулгүй байдлын гол хүчин зүйлүүдийн нэг” бөгөөд “дотоод, гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн нэг” гэж үзэх ёстой гэжээ. Номлолд хэт халалт, ган гачиг, мөнх цэвдэг хайлах зэрэг ноцтой сорилтыг тодорхойлохын зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлтөөс бий болох “ашиг тус”-ыг товойлгосон байна.⁹ Түүнчлэн ОХУ нь өргөн уудам нутаг дэвсгэр, асар их усны нөөц, уур амьсгалын эмзэг бүс нутагт амьдардаг хүн амын тоо харьцангуй цөөн тул дэлхийн бусад улс оронтой харьцуулахад дасан зохицох чадавхтай хэмээн онцолжээ. Бодит байдалд Оросын орон нутгийн эрх баригчид уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг арилгахад хангалттай бэлтгэлгүй байгааг мэргэжилтнүүд онцолж байгаа.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлого, арга хэмжээ

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудалд ихээхэн хойрго хандсаар ирсэн ОХУ сүүлийн жилүүдэд дасан зохицох асуудалд тодорхой анхаарал хандуулах болсон.

ОХУ-ын Засгийн газар 2022 оны зургаадугаар сард уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ, Эдийн засгийн хөгжлийн яамны зөвлөмжид үндэслэн тээвэр, түлш эрчим хүч, барилга орон сууц, хөдөө аж ахуй, загасчлал, байгаль орчны менежмент, эрүүл мэнд, Арктик, иргэний хамгаалалт, онцгой байдал, аж үйлдвэр, худалдаа зэрэг 10 салбарт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөгөөг баталсан.¹⁰ Белгород, Волгоград, Вологда, Кемерово, Курск, Пенза, Крым гэсэн бүс нутгийн төлөвлөгөөг мөн боловсруулсан бөгөөд эдгээр нь орон нутгийн цаг агаарын эрс тэс үзэгдэл,

⁷ Манай гарагийн нийт ойгоор бүрхэгдсэн талбайн 23%, тус улсын нийт нутаг дэвсгэрийн 49%-ийг эзлэн орших 850 сая га талбай байгалийн ой бүхий арвин нөөцтэй ч уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны улмаас сэрүүн бүсийн энэ их ой хурдан доройтох, хомсдох аюул нүүрлэж байна.

⁸ Yorke, O. (2020.11.19). Deforestation in Russia: Depleting the Lungs of the World. <https://earth.org/deforestation-in-russia/>

⁹ Kaschowitz S. (2024). Russia's stance on climate change. Powerless towards nature, paranoid towards policy, pragmatic towards profit. Friedrich Ebert Stiftung Regional office for cooperation and peace in Europe. <https://library.fes.de/pdf-files/bueros/wien/21467.pdf>

¹⁰ The Moscow Times. “Russia Plans to ‘adapt’ to Climate Change.” The Moscow Times, December 15, 2025. <https://www.themoscowtimes.com/2020/01/06/russia-plans-to-adapt-to-climate-change-a68814>.

хөдөө аж ахуйн эмзэг байдал, усны хомсдол болон орон нутгийн бусад нөлөөллийг тусгасан аж. Бусад бүс нутаг, мужийн хувьд холбогдох төлөвлөгөөг боловсруулах шатанд байна. Эдгээр баримт бичиг нь Оросын хүн амын уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдлыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ Арктикийн усан замын гарц, хөдөө аж ахуйн эдэлбэр газрыг өргөтгөх, ойн бүтээмжийг нэмэгдүүлэх, өвлийн улиралд халаалтын эрчим хүчний зардлыг бууруулах зэрэг уур амьсгалын өөрчлөлтөөс бий болж болзошгүй давуу талуудыг ашиглахад түлхүү анхаарсан ажээ. Түүнчлэн дасан зохицох арга хэмжээний санхүүжилт, хэрхэн хэрэгжүүлэх талаар хязгаарлагдмал гэж үзэж болно.

ОХУ одоогоор эмзэг байдлыг бууруулах, дасан зохицох талаар маш бага арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Оросын Засгийн газар газар тариалангийн даатгалд татаас олгодог боловч хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид хураамжийг хэт өндөр гэж үздэгээс газар тариалан, мал амьтны ердөө таван хувь нь л даатгуулсан байдаг ба зарим тариаланч ургац алдах үед холбооны сангаас авах тусламжид найддаг. Богино хугацаанд үр тарианы хомсдолтой жилүүдэд холбооны нөөц хүнсний дарамтыг бууруулж болох ч урт хугацаанд буюу ойрын 50 жилийн уур амьсгалын эрс өөрчлөлтөд дээрх арга хэмжээ хангалтгүй болох юм. Иймд ирээдүйд учирч болзошгүй хүнсний хямралын эрсдэлийг бууруулахын тулд орон нутгийн уур амьсгал, ландшафт, хөрсөнд нийцсэн үр тарианы сортыг тариалах талаар бүс нутаг хоорондын солилцоог нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэн 2018 оноос хойш Засгийн газраас нь тариалалтын гол төрөл зүйл (буудай, арвай, чихрийн нишингэ, төмс)-ийн орон нутагт тохирсон үр сортыг хөгжүүлэх чиглэлд технологийн хөрөнгө оруулалтыг эрчимжүүлсэн боловч улс төрийн гол үндэслэл нь уур амьсгалд дасан зохицох бус үндэсний хэмжээнд хүнсний аюулгүй байдлыг хангах явдал байлаа.

Оросын ихэнх хотод уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход стратегийн бодлогын хэрэгсэл, засаглалын чадавх, улс төр, төсвийн бие даасан байдал дутагдаж байна. Москва хот 2060 он гэхэд нүүрстөрөгчийн хувьд саармаг болох үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан боловч албан ёсоор батлаагүй, хэрэгжих эсэх нь тодорхойгүй байна. Санкт-Петербург “Хотын стратеги төлөвлөгөө”-ндөө уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тухай хэсгийг тусгасан боловч хотын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө байхгүй.¹¹ Бусад томоохон хотын хувьд стратегийн төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийг тусгах нь ховор байна.

ОХУ-ын мөнх цэвдэгтэй бүс нутгийн хотуудад дасан зохицох хамгийн их хэрэгцээ бий. Уур амьсгалын тодорхойгүй загварууд, хөрөнгө оруулалтын болон ашиглалтын өндөр зардлаас үүдэлтэй инженерийн зураг төсөл, барилга угсралтын ажилд онцгой хүндрэл учрах төлөвтэй. Мөнх цэвдэгтэй бүс нутгуудад хийсэн аюул эрсдэлийн үнэлгээгээр Уралын нурууны баруун хойд хэсэг, Сибирийн баруун хойд

¹¹ Javeline, D., Orttung, R., Robertson, G., Arnold, R., Barnes, A., Henry, L., Holland, E., Omelicheva, M., Rutland, P., Schatz, E., Schenk, C., Semenov, A., Sperling, V., McIntosh Sundstrom, L., Troitskiy, M., Twigg, J., & Wengle, S. (2024). Russia in a changing climate. WIREs Climate Change, 15(2), e872. <https://doi.org/10.1002/wcc.872>

болон төв хэсэг аюулын өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. Гэвч дэд бүтэц, холбогдох эдийн засгийн өртгийн талаарх энэ төрлийн үнэлгээ хомс байна.

Мөнх цэвдэгтэй бүс нутгуудын дэд бүтцэд өмнө учирч байсан хохирлууд Орос уур амьсгалын өөрчлөлтийн хүндрэлийг шийдвэрлэх чадавхгүй, эсвэл хүсэлгүй байгааг харуулна. Лена голын 2001 оны үерийн дараа эрх баригчид урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 400 дахин их өртгөөр үерийн голомтод орших сүйрсэн Ленск хотыг сэргээн босгосон аж. ОХУ-ын Ерөнхий сайдын орлогч Виктория Абрамченко 2021 оны 10 дугаар сард уур “амьсгалын шилжигсэд” буюу уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, нөхцөл байдлын улмаас шилжин суурьшигчид бий болж буйг хүлээн зөвшөөрч, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зайлшгүй хэрэгцээ шаардлага байгааг нотолсон. Гэвч шилжилт хөдөлгөөний талаар дасан зохицох төлөвлөлтөд ч дурдаагүй, бодлогын асуудал, олон нийтийн хэлэлцүүлгийн сэдэв болж гарч ирэхгүй байгаа нь анхаарууштай.

Хоёр. ОХУ-ын уур амьсгалын аюулгүй байдлын стратеги

ОХУ-ын 2021 оны үндэсний аюулгүй байдлын стратегид уур амьсгалын өөрчлөлтийг хамарсан экологийн аюулгүй байдлын ойлголт багтсан. Түүнчлэн тухайн жил ОХУ 2050 он гэхэд дотоодын хүлэмжийн хийн ялгарлыг бага түвшинд хүргэх зорилготой нийгэм-эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан гаргасан. Харин 2023 онд гадаад бодлогын үзэл баримтлалаа шинэчлэхийн зэрэгцээ уур амьсгалын номлолоо дахин боловсруулснаар эдгээр шинэчлэлийг үндэсний аюулгүй байдлын зорилгод нийцүүлсэн.

Нүүрстөрөгчийн хувьд саармаг байдалд шилжих нь Оросын ашиг сонирхолд хохирол учруулахгүй боловч ногоон эрчим хүч рүү хурдацтай шилжих нь эдгээр ашиг сонирхолд заналхийлнэ гэж ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин мэдэгдэж байв. Оросын удирдагчид ногоон эдийн засагт шилжих нь нөөцийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж, улмаар нүүрсхүчлийн хийн эх үүсвэрүүдийг санхүүжилтгүй болгох, эрчим хүчний хямралын эрсдэлийг өсгөх магадлалтай гэж үздэг. Мөн тус улсын гадна хэрэгжиж буй уур амьсгалын хатуу бодлого, зохицуулалт улсын төсөв болон хувийн хэвшилд ихээхэн орлого оруулдаг газрын тос, хийн экспортыг хязгаарлана гэж эмээдэг. Ийм ч учраас Оросын уур амьсгалын аюулгүй байдлын стратеги нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогыг чухалчлан, нүүрстөрөгчөөс хамааралтай эдийн засгаа хамгаалахын зэрэгцээ геополитикийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх хөшүүрэг болгон ашиглахад чиглэж байна.

Арктик: Уур амьсгалын өөрчлөлт геополитикийн боломж болох нь

Дэлхийн нээгдэж амжаагүй байгаа газрын тосны нөөцийн 13, байгалийн хийн 30 хувь нь Арктикийн мөсөн дор бий гэж үздэг. Тиймээс дэлхийн дулаарлын улмаас эрчимтэй хайлж буй Арктик ойрын ирээдүйд дэлхийн их гүрнүүдийн өрсөлдөөний нэг талбар болох төлөвтэй. Арктикийн эргийн 53 хувь нь Оросын газар нутагтай хил

залгаа бөгөөд Арктик дахь Хойд тэнгисийн зам (Northern sea route) жилийн дөрвөн улиралд нээлттэй болсноор Оросын эдийн засгийн онцгой бүсэд багтах энэхүү усан зам Хятад, Европыг холбосон шинэ Суэцийн суваг болно гэж үзэж буй.

Москва энэ бүс нутгийг үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн өсөлт, дэлхийн хүчний төлөвт чухал ач холбогдолтой хэмээн үздэг. Украинтай хийж буй дайнаас өмнө Арктикийн стратеги (2008), Арктикийн бодлого (2020) гэсэн үндсэн баримт бичгүүд Оросын Арктик дахь бодлогыг тодорхойлж, тус улсын эдийн засгийн аюулгүй байдал, геополитикийн стратегид бүс нутгийн үүрэг оролцоог онцолж байв. Арктик дахь ашигт малтмалын арвин их нөөцийг эргэлтэнд оруулахын тулд Орос Роснефть, Газпром зэрэг төрийн өмчит компаниар дамжуулан ихээхэн хөрөнгө оруулж, хайгуулын нүсэр төслүүдийг эхлүүлсэн. Эдийн засгийн үр ашгаас гадна геополитикийн асуудлаас үл хамаарч Канад, Норвег, Америк зэрэг Арктикийн улстай байгаль орчны хамгааллын чиглэлээр хамтын ажиллагааг өрнүүлж байв. Түүнчлэн НАТО-гийн тэлэлтийн хариу арга хэмжээ болгон цэрэг зэвсгийн зузаатгал (Зөвлөлтийн үеийн цэргийн баазуудыг эргэн сэргээх, дэвшилтэт радарын систем суурилуулах, цөмийн хөдөлгүүрт мөс зүсэгчийн флотоо өргөтгөх) хийж байв. Гэвч 2022 онд Украинтай дайн хийж эхэлснээр Арктик дахь бодлого нь өөрчлөгдсөн. Нэгт, барууны хоригийн улмаас газрын тос, байгалийн хийн төслүүдээс барууны хөрөнгө оруулагчид гарч, технологийн саадтай тулгарсан тул шинэ хөрөнгө оруулагч болох Хятадтай түншлэх болов. Хоёрт, НАТО хойд зүгт тэлснээр Арктикт цэргийн хурцадмал байдал нэмэгдэж, Москва Арктикт цэргийн оролцоогоо өсгөхөд хүргэв. Гуравт, Орос Хятадтай хамтын ажиллагаагаа “Туйлын торгоны зам” санаачилгын хүрээнд эрчимжүүлэх болов. Өрнөдийн компаниуд Хойд тэнгисийн замын дагуу үйл ажиллагаагаа бууруулж байхад Орос Арктикийн дэд бүтцийн төслүүдээ хадгалж үлдэхийн тулд Хятадын хөрөнгө оруулалтад түшиглэж байна.¹² Хойд тэнгисийн замын гарцыг хяналтдаа байлгах зорилгын эхлэл болох томоохон хөрөнгө оруулалтууд хэдийн эхэлж, усан замын хоёр төгсгөл (Мурманск, Владивосток)-д баригдаж буй мега боомтуудын барилгын ажил 2026 онд дуусах төлөвлөгөөтэй, зам дагуух хоёр боомт (Сабетта, Тикси)-ын барилга байгууламжийн ажил үргэлжилж байна. Усан замаар 2035 он гэхэд жилд 270 сая тонн ачаа тээвэрлэгдэнэ гэж тооцож буй.

Өрнөдийн бус уур амьсгалын эвсэл

Өрнөдийн хориг арга хэмжээ, нүүрстөрөгчийн хил дамнасан татвар Оросын газрын тос, хийн экспортыг заналхийлж байгаа тул Москва шинэ зах зээл, шинэ түнш хайж байна. Ойжуулалт, цөмийн эрчим хүч, дасан зохицох дэд бүтцийн бүтээн байгуулалт зэрэг хамтарсан төслөөр дамжуулан уур амьсгалын хамтын ажиллагааг хэрэгжүүлж буй. Орос БРИКС, ШХАБ, Евроазийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ) зэрэг олон улсын байгууллагад өрнөд давамгайлсан уур амьсгалын засаглалын эсрэг алтернатив замналыг хамгаалагч болон гарч ирж байна. Тухайлбал: БРИКС-ийн

¹² Sönmez, Doğuş. “Russia’s Changing Arctic Policy: From Economic Ambitions to Military Dominance.” The Loop, April 11, 2025. <https://theloop.ecpr.eu/russias-changing-arctic-policy-from-economic-ambitions-to-military-dominance/>.

хурлуудад Оросын албан тушаалтнууд Евроазийн уур амьсгалын асуудлаар хүчин чармайлтаа нэгтгэх шаардлагыг олонтоо онцолж, 2023 онд Дубайд болсон COP28 бага хурал дээр Оросын төлөөлөгчид БРИКС малтмал түлшийг хурдан хугацаанд бүрэн халахад бус бие даасан тусгаар байдал болон аажим шилжилтийг нэн тэргүүнд тавьсан алтернатив замналын тавцан байх боломжтой гэж мэдэгдэж байв.¹³

Исламабад хотноо 2024 онд болсон ШХАБ-ын дээд хэмжээний уулзалт уур амьсгалын өөрчлөлтийг албан ёсоор гол сэдэв болгон авч үзэн, уур амьсгалын асуудлаар түр ажлын хэсэг байгуулсан. Мөн бүс нутгийн уур амьсгалын сан байгуулах, үндэсний уур амьсгалын үйл ажиллагааны төлөвлөгөөг ШХАБ-ын нийтлэг үзэл баримтлалтай уялдуулах асуудлыг хэлэлцсэн аж. Үүний дараа 2024 оны есдүгээр сард Хятад-Оросын “Ногоон яриа хэлэлцээ: Тогтвортой ирээдүйн төлөө Хятад ба Орос” форумар Хятадын тал нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулах бодлогын амжилтаа танилцуулж, Оросын тал ШХАБ-ын хүрээнд өөрийн нүүрстөрөгчийн салбаруудыг Хятадын зах зээлд гаргахад түлхүү анхаарч байв. Үүнээс бий болох үр ашиг нь тодорхой. Өрнөдийн бус улсуудтай ойртон түншилснээр зах зээлээ төрөлжүүлж, хориг арга хэмжээг сөрөн тэсвэрлэх чадавхтай болж буй.

Гэвч бодит эрсдэлүүд бас бий. Эвсэл дэх улсууд өөр өөрийн ашиг сонирхолтой тул нөхөрлөл сул, түүнчлэн дэлхий нийтээр нүүрстөрөгчгүйжих дарамт улам нэмэгдэж буй үед нүүрстөрөгчид суурилсан стратеги урт хугацаандаа явцгүй юм. Үнэн хэрэгтээ ОХУ-ын БРИКС, ШХАБ, ЕАЭЗХ-ны түншүүдтэй уур амьсгалын зохицуулалтыг уялдуулах оролдлого төдийлэн амжилт олохгүй байна. Казахстан ЕХ-той хамтын ажиллагааны улмаас Оростой уур амьсгалын дэглэмээ нэгтгэхээс ухарсан. Хятад Оростой ойрын хамтрагч боловч ил тод байдалд суурилсан, бага нүүрстөрөгчийн хөгжлийг тэргүүлэх бодлого баримталдаг тул Оросын тодорхой бус уур амьсгалын институттэй холбогдох логик үндэслэл бага. Азийн түншүүд Оростой зарим талаар ижил байр суурьтай (жишээлбэл: малтмал түлшийг удаан хугацаанд ашиглах, Өрнөдийн нүүрстөрөгчийн талаарх бодлогыг эсэргүүцэх) ч тэдний санаачилгыг тунхаг, амлалтаас цааш ахиулахаас зайлсхийж байна уу гэж харагдана.

Дүгнэлт

ОХУ-ын уур амьсгалын аюулгүй байдлын стратеги нь уур амьсгалын өөрчлөлтийг нэг талаас эмзэг байдлын эх сурвалж, нөгөө талаас геополитикийн хөшүүрэг болгон авч үздэг. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд хойрго хандаж ирсэн Москва дотоодын түвшинд мөнх цэвдгийн хайлалт, цаг агаарын эрс тэс үзэгдэл, гамшгаас үүдэлтэй эмзэг байдлыг хүлээн зөвшөөрч, чухал салбаруудад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогыг боловсруулж эхлээд байна. Гэвч бодлогын арга хэрэгсэл, засаглалын чадавх сул, төсөв санхүүжилт хязгаарлагдмал байгаа нь бодит хэрэгжилтийг сааруулж байна. Нөгөө талаас, Орос уур амьсгалын

¹³ Anna Korppoo & Alex Alisson (2025). Russia's Non-Western Climate Coalition Genuine Consensus or Just Hot Air? Climate Strategies. <https://climatestrategies.org/wp-content/uploads/2025/06/RUSSIAS-NON-WESTERN-CLIMATE-COALITION-Genuine-Consensus-or-Just-Hot-Air-1.pdf>

өөрчлөлтийг геополитикийн боломж хэмээн харж буй. Арктикт дэд бүтцийг өргөжүүлэх, бие даасан байдлаа бататгах, Хойд тэнгисийн замыг дэлхийн тээврийн коридор болгон сурталчлах замаар Москва хойд бүс нутаг дахь уур амьсгалын өөрчлөлтийг стратегийн давуу тал болгон хувиргахыг зорьж байна.

Гадна талдаа Орос БРИКС, ШХАБ, ЕАЭЗХ зэрэг платформоор дамжуулан Ази, өрнөдийн бус улсуудын уур амьсгалын эвсэл байгуулах оролдлого нь барууны манлайлал бүхий уур амьсгалын засаглалыг тэнцвэржүүлэх, нүүрстөрөгч дээр суурилсан дотоодын төслүүдээ хамтын зах зээлийн дэд бүтэц, механизмын хүрээнд хууль ёсны болгох зорилгыг нь давхар илэрхийлнэ. Энэ бүхнийг нэгтгэн дүгнэвэл, Оросын уур амьсгалын аюулгүй байдлын стратеги дахь сорилт ба боломж гэсэн хоёр талт динамик нь уур амьсгалын өөрчлөлт дэлхийн аюулгүй байдал болон их гүрнүүдийн стратегийн зан төлөвийг хэрхэн өөрчилж байгаагийн илрэл юм.

Оросын малтмал түлшний хамаарал болон уур амьсгалын өөрчлөлтийг стратегийн давуу тал болгон хувиргах оролдлого нь бүс нутгийн эрчим хүчний харилцан хамаарлыг улам гүнзгийрүүлж, Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний тогтвортой байдлыг хангах хүчин чармайлтыг хүндрүүлж болзошгүй. Үүний зэрэгцээ, Өрнөдийн тогтоосон өнөөгийн хүрээнээс гадуурх уур амьсгалын засаглалын эвсэл байгуулах нь олон улсын норм, хэлэлцээрт нөлөөлөх эрсдэл бүхий, Монгол Улсын хувьд анхаарах шаардлагатай шинэ дарамт, боломжуудыг бий болгож байна.

Монгол Улсад уур амьсгалын яриа хэлэлцээ болон дэд бүтцийн хамтын ажиллагаанд оролцох боломжийг нээхийн зэрэгцээ, хэрэв хамтын байр суурь нь үндэсний тэргүүлэх чиглэлтэй нийцэхгүй аваас бие даасан, хараат бус шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Эх сурвалжийн жагсаалт

Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт батлах тухай Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 407 дугаар тогтоол.

Anna Korppoo & Alex Alisson (2025). Russia's Non-Western Climate Coalition Genuine Consensus or Just Hot Air? Climate Strategies. <https://climatestrategies.org/wp-content/uploads/2025/06/RUSSIAS-NON-WESTERN-CLIMATE-COALITION-Genuine-Consensus-or-Just-Hot-Air-1.pdf>

Climate Doctrine of the Russian Federation (2009). <https://www.climate-laws.org/geographies/russia/policies/climate-doctrine-of-the-russian-federation>

Cordell, J. (2021.09.07). Climate change threatens Russia's economic growth, watchdog warns. *The Moscow Times*. <https://www.themoscowtimes.com/2020/01/14/climate-change-threatens-russias-economic-growth-watchdog-warns-a68878> (2022.11.20-нд үзсэн).

Javeline, D., Orttung, R., Robertson, G., Arnold, R., Barnes, A., Henry, L., Holland, E., Omelicheva, M., Rutland, P., Schatz, E., Schenk, C., Semenov, A., Sperling, V., McIntosh Sundstrom, L., Troitskiy, M., Twigg, J., & Wengle, S. (2024). Russia in a changing climate. *WIREs Climate Change*, 15(2), e872. <https://doi.org/10.1002/wcc.872>

Kaschowitz S. (2024). Russia's stance on climate change. Powerless towards nature, paranoid towards policy, pragmatic towards profit. Friedrich Ebert Stiftung Regional office for cooperation and peace in Europe. <https://library.fes.de/pdf-files/bueros/wien/21467.pdf>

Koralova L. (2024.04.24). Russia's epic floods expose lack of preparedness for climate crisis. *The Moscow Times*. <https://www.themoscowtimes.com/2024/04/24/russias-epic-floods-expose-lack-of-preparedness-for-climate-crisis-a84943> (2024.11.20-нд үзсэн)

Russia approves New Climate Doctrine. Accessed December 15, 2025. <https://forumvostok.ru/en/news/v-rossii-utverzhdena-novaja-klimaticheskaja-doktrina/>.

Sönmez, Doğuş. "Russia's Changing Arctic Policy: From Economic Ambitions to Military Dominance." *The Loop*, April 11, 2025. <https://theloop.ecpr.eu/russias-changing-arctic-policy-from-economic-ambitions-to-military-dominance/>.

The Moscow Times. "Russia Plans to 'adapt' to Climate Change." *The Moscow Times*, December 15, 2025. <https://www.themoscowtimes.com/2020/01/06/russia-plans-to-adapt-to-climate-change-a68814>.

Yorke, O. (2020.11.19). Deforestation in Russia: Depleting the Lungs of the World. <https://earth.org/deforestation-in-russia/>

Russia's Climate Security Strategy

Nominbolor Khurel

Ph.D. candidate, Senior expert, nominbolor@iss.gov.mn

Institute for Strategic Studies of National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Abstract

Russia, the largest country in the world by land area, is highly vulnerable to the impacts of climate change, particularly in the Arctic and permafrost regions where warming is occurring up to four times faster than the global average. This poses risks to key sectors such as infrastructure, biodiversity, energy, and agriculture. Moscow has pledged to achieve carbon neutrality by 2060 and has developed policy documents aimed at reducing greenhouse gas emissions and promoting sustainable development. However, experts criticize these measures as largely symbolic and unlikely to bring about real change, noting that excessive dependence on fossil fuels and the primacy of geopolitical objectives continue to outweigh commitments to mitigating climate change.

Thus, climate change presents Russia not only with domestic adaptation challenges but also with a strategic instrument in international relations. This article analyzes Russia's position, approach, and strategy on climate change. It concludes that the dual nature of Russia's climate security strat-

egy—domestic vulnerability and geopolitical leverage—illustrates how climate change is reshaping global security and the strategic behavior of major powers.

Keywords: *Climate change, vulnerability, Arctic, geopolitical leverage, Non-western climate coalition*

Received: December 5, 2025 | Accepted: December 23, 2025 | Published online: December 30, 2025



© The Author(s) 2025

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.